



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.04.22 № 03/654

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зарласан НХААГ/20240101295/01/01 дугаартай Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ-2 ажлын тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	ТШЗ 19.1-т Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн хүснэгтийн 3-т “Геодезийн инженер” албан тушаалтан нь Геодезийн инженер мэргэжилтэй байхыг шаардсан байна. Газрын Кадастр мэргэжлээр Бакалаврын зэрэгтэйгээр дипломтой төгсөөд авто замын геодези болон авто замын зураг төсөлд геодезийн албан тушаалтай 3 жил ажилласан ажилтныг “Геодезийн инженер” албан тушаалтнаар тооцох уу?	Геодезийн инженер нь Геодезийн инженер мэргэжилтэй байна.
2	ТШЗ 19.3-т Ажил гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн Багц 5,7,8-т 5.2.3.1 Авто зам барих. Бүх төрлийн асфальтбетон, хөнгөвчилсэн хучилттай авто замыг барих (Их засвар шинэчлэлт) тусгай зөвшөөрөл нь Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгодог 2.8.2.1.2 15 км хүртэл хатуу хучилттай авто зам барих тусгай зөвшөөрлөөр дүйцүүлэн хангах болох уу?	5.2.3.1 Авто зам барих. Бүх төрлийн асфальтбетон, хөнгөвчилсэн хучилттай авто замыг барих (Их засвар шинэчлэлт) тусгай зөвшөөрөл нь Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгодог 2.8.2.1.2 15 км хүртэл хатуу хучилттай авто зам барих тусгай зөвшөөрлөөр дүйцүүлж болно.

ТШЗ 9.4 Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэнд тооцно.

Та бүхэн манай газраас зарлагдсан тендер сонгон шалгаруулалтад амжилттай оролцохыг хүсье.